

**Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын
“Орхон хөгжил” ХК-ийн
2024 оны газар тариалангийн
үйлдвэрлэл болон үйл ажиллагааны тайлан**

1. Тариалалтын талаар:

Тайлант 2024 онд тариалангийн ажилд ашиглах техник тоног төхөөрөмжийн засварыг хугацаанд нь хийж гүйцэтгэсэн. Мөн тоног төхөөрөмжөө шинэчлэн хор цацагч, үрлүүр, сийрүүлүүр хийсэн. 2021 онд 1 ширхэг комбайн, трактор худалдаж авсан, 2023 онд техникийн агуулахын барилга, ажилчидын сууц, гал тогооны байр барьж, 2024 онд Виктор 410 маркийн комбайны жатак 62 сая төгрөгөөр худалдан авсан.

Тариалалтыг 5-р сарын 04-ны өдрөөс 5-р сарын 29-ныг дуустал хугацаанд 483 га-д улаан буудай, 400 га-д рапс, нийт 883 га-д хийж гүйцэтгэв. Тарихын өмнөх боловсруулалтыг трактор, сийрүүлэгчээр гүйцэтгэсэн бөгөөд 130 тн үрийг 8-10 см-ийн гүнд тариалав.

2. Ургац хураалтын талаар;

Комбайны засварын ажлыг хугацаанд нь хийж гүйцэтгэн 4 трактор, 3 комбайныг бэлэн болгож ажиллуулсан. Хураалтын явцад комбайны эвдрэл бага зэрэг гарсан боловч цаг тухайд засварласан.

Тайлант онд 280 га талбайд уринш хийсэн. Уриншийн талбайд гербицид хороор боловсруулалт хийсэн. Хор цацах ажлыг 6-р сарын 15-аас 6-р сарын 25 хүртэл 10 хоног гүйцэтгэв. Уриншийн 2-р үеийн боловсруулалтыг 8-р сарын 8-аас эхэлж сийрүүлэлтийг 10 хоногт хийж гүйцэтгэлээ.

Ургац хураалт өөрийн автомашин техникийг ашиглан 40-45 хоног үргэлжлэв.

3. Үтрэмийн ажлын талаар;

Хураасан будаа, рапсаа өөрийн ачигч, цэвэрлэгч, сортлогч машиныг ашиглан стандартад нийцүүлэн “УБ гурил” ХХК, “Майнд теч” ХХК-д борлуулсан болно.

2024 онд 483 га-д улаан буудай тариалж 1 га-гаас 15 цн буюу нийт 724,5 тн ургац хураасан бөгөөд үүнээс үрэнд 160 тн будаа хадгалж, 552,4 тн улаан буудай борлуулсан 400 га-д рапс тариалж 1 га-гаас 3,5 цн буюу нийт 143,1 тн ургац хураан авч борлуулан 812,9 сая төгрөгний орлого олж, үүнээс 725,8 сая төгрөгийн зардал гарсан бөгөөд сая төгрөгийн 87,1 сая төгрөгийн ашигтай ажилласан.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Д. ЖАРГАЛСАЙХАН